



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/511

Булган сум

**Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 48 дугаар зүйлийн 48.1, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 тоот тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 1 дүгээр хавсралтын 6 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн ам, бэлчээрийн усан хангамж, таримал ойн услагаа арчилгааг нэмэгдүүлэх зориулалтаар шинээр гаргасан худгийн барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хэлтсийн дарга)
Гишүүд: Сумдын Засаг даргын Тамгын газрын төлөөлөл
Сумдын багийн Засаг дарга нар
Малчдын болон эзэмшигчдийн төлөөлөл
Архивын байгууллагын төлөөлөл
Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл
Нарийн бичгийн дарга: Г.Гантулга (Хүнс, хөдөө аж ахуйн газрын усны инженер)

2. Худаг эзэмшигчийг тогтоож, “худаг ашиглалтын гэрээ”-г эзэмшигчтэй байгуулж ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Чанарын шаардлага хангасан тоног төхөөрөмжийг хүлээн авч, хууль тогтоомжийн дагуу баримт бичиг бүрдүүлж ажиллахыг ажлын хэсэг (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6300010522